

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/78/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70371889 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 108

танай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 18 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,180.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 16,723.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,407.0 мянган төгрөгийн "Хөгжим 7 эгшиг" төслийн хөгжим, цэцэрлэгийн эцэг, эхийн хандиваар хандивласан 10,400.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг тус тус холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050136

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 1,080,582.2 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 24.8 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 126 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	310,384,161.10	140,375,983.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	237,833,528.10	22,762,961.04
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	237,833,528.10	22,762,961.04
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	72,550,633.00	117,613,022.00
351	Түүхий эд материал	1,648,932.00	964,025.00
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	1,648,932.00	964,025.00
354	Хангамжийн материал	70,901,701.00	116,648,997.00
35410	Бичиг хэргийн материал	1,031,500.00	3,919,800.00
35420	Аж ахуйн материал	1,635,049.00	16,387,510.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,143,100.00	2,666,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал	6,043,950.00	8,530,650.00
3546	Хүнсний материал	7,639,675.00	11,207,460.00
35470	Бусад хангамжийн материал	51,408,427.00	73,937,577.00
36	НӨӨЦ БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,533,247,770.64	1,525,004,000.67
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,533,247,770.64	1,525,004,000.67
392	Биет хөрөнгө	1,088,147,770.64	1,079,904,000.67
39201	Барилга, байгууламж орон сууц	1,194,089,956.00	1,194,089,956.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(204,900,754.28)	(245,143,756.88)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,827,185.00	121,327,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,357,755.48)	(26,331,615.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,442,006.00	60,630,070.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,055,207.43)	(29,230,898.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,133,425.00	16,133,425.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,031,084.17)	(11,570,178.73)
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	445,100,000.00	445,100,000.00
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	445,100,000.00	445,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,843,631,931.74	1,665,379,983.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,843,631,931.74	1,665,338,883.71
41	Богино хугацаат өр төлбөр	-	41,100.00
413	Өглөг	-	41,100.00
4136	Бусад өглөг	-	41,100.00
41361	байгууллагад өгөх өглөг	-	41,100.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,843,631,931.74	1,665,338,883.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	722,511,532.00	722,511,532.00
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	(82,264,172.28)	(260,557,220.31)
51210	Өмнөх үеийн үр дүн	(82,264,172.28)	(82,264,172.28)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(178,293,048.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,203,384,572.02	1,203,384,572.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,843,631,931.74	1,665,379,983.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,369,257,980.00	1,372,883,120.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,503,280.00	86,512,520.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,503,280.00	86,512,520.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,980.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,240,300.00	7,175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	47,710,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	6,214,000.00	31,592,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,754,700.00	1,286,370,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,257,267,700.00	1,214,353,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,257,267,700.00	1,214,353,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,487,000.00	72,017,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	67,487,000.00	72,017,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,272,113,791.27	1,550,141,264.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,272,113,791.27	1,550,141,264.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,267,579,536.87	1,547,647,063.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	865,700,542.07	1,080,582,159.06
210101	Үндсэн цалин	582,736,214.71	704,212,709.15
210102	Нэмэгдэл	256,295,702.36	299,276,193.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,154,500.00
210104	Урамшуулал	26,668,625.00	38,938,756.63
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,463,783.78	134,624,000.00
210201	Тэтгэврийн даатгал	74,031,169.79	91,337,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,592,583.95	10,821,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,506,200.22	5,410,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,266,786.05	5,410,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,067,043.77	21,643,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,452,745.60	59,525,698.87
210301	Гэрэл, цахилгаан	11,606,154.68	16,146,767.68
210302	Түлш, халаалт	19,692,123.00	17,813,754.20
210303	Цэвэр, бохир ус	19,154,467.92	25,565,176.99

210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,878,697.00	6,360,111.00
210401	Бичиг хэрэг	-	-
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,010.00	1,227,000.00
210408	Бараа материал акталсны зардал	4,844,687.00	5,133,111.00
2105	Нормативт зардал	133,810,463.00	159,027,485.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	155,000.00	70,000.00
210502	Хоол, хүнс	133,655,463.00	158,957,485.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,317,850.00	12,857,700.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	8,317,850.00	12,857,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,138,800.00	3,281,605.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,138,800.00	3,281,605.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,816,655.42	91,388,304.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,281,170.00	19,087,238.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,683,700.00	10,207,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,851,785.42	62,093,866.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,534,254.40	2,494,201.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,534,254.40	2,494,201.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,534,254.40	2,494,201.13
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,034,903.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,034,903.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	97,144,188.73	(178,293,048.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	97,144,188.73	(178,293,048.03)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,324,803,680.00	1,286,405,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,980.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,980.00	35,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
120009	Бусад орлого	48,980.00	35,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,754,700.00	1,286,370,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,257,267,700.00	1,214,353,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,257,267,700.00	1,214,353,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,487,000.00	72,017,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,487,000.00	72,017,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,218,918,348.85	1,501,476,167.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,218,918,348.85	1,501,476,167.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,214,384,094.45	1,498,981,965.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	865,700,542.07	1,080,582,159.06
210101	Үндсэн цалин	582,736,214.71	704,212,709.15
210102	Нэмэгдэл	256,295,702.36	299,276,193.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,154,500.00
210104	Урамшуулал	26,668,625.00	38,938,756.63
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,463,783.78	134,624,000.00
210201	Тэтгэврийн даатгалын	74,031,169.79	91,337,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын	9,592,583.95	10,821,800.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,506,200.22	5,410,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	4,266,786.05	5,410,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	17,067,043.77	21,643,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,452,745.60	59,525,698.87
210301	Гэрэл, цахилгаан	11,606,154.68	16,146,767.68
210302	Түлш, халаалт	19,692,123.00	17,813,754.20
210303	Цэвэр, бохир ус	19,154,467.92	25,565,176.99
2104	Хангамж, бараа материал	-	-
2105	Нормативт зардал	132,804,323.00	162,525,270.00
210502	Хоол, хүнс	132,804,323.00	162,525,270.00
2106	Эд хогшил урсгал засвар	12,500,000.00	9,997,600.00
210601	Багаж техник хэрэгсэл		
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	12,500,000.00	9,997,600.00

2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	3,918,800.00	7,041,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,918,800.00	7,041,605.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,543,900.00	44,685,633.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,194,500.00	31,670,433.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,349,400.00	13,015,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,534,254.40	2,494,201.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	.	.
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,534,254.40	2,494,201.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,534,254.40	2,494,201.13
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	105,885,331.15	(215,070,567.06)
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	-	
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	105,885,331.15	(215,070,567.06)
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	237,833,528.10
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,762,961.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	478,695,439.00	571,185,048.59	868,192,980.87	-	1,918,073,468.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(179,408,361.01)	-	1,746,487,743.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			97,144,188.73		97,144,188.73
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(82,264,172.28)	-	1,843,631,931.74
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(82,264,172.28)	-	1,843,631,931.74
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			(178,293,048.03)		(178,293,048.03)
D08	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	722,511,532.00	1,203,384,572.02	(260,557,220.31)	-	1,665,338,883.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,526,107,300.00	1,498,946,965.93	(27,160,334.07)	98.22
21	Урсгал зардлын дүн	1,526,107,300.00	1,498,946,965.93	(27,160,334.07)	98.22
210	Бараа үйлчилгээний зардал	1,526,107,300.00	1,498,946,965.93	(27,160,334.07)	98.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,082,174,500.00	1,080,582,159.06	(1,592,340.94)	99.85
210101	Үндсэн цалин	730,495,400.00	704,212,709.15	(26,282,690.85)	96.40
210102	Нэмэгдэл	324,802,600.00	299,276,193.28	(25,526,406.72)	92.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,154,500.00	38,154,500.00	
210104	Урамшуулал	26,876,500.00	38,938,756.63	12,062,256.63	144.88
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,624,000.00	134,624,000.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	91,337,100.00	91,337,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,821,800.00	10,821,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,800.00	5,410,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,410,800.00	5,410,800.00	-	100.00
210205	ЭМД-ын хураамж	21,643,500.00	21,643,500.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,864,600.00	59,525,698.87	(7,338,901.13)	89.02
210301	Гэрэл цахилгааны зардал	17,706,800.00	16,146,767.68	(1,560,032.32)	91.19
210302	Түлш, халаалтын зардал	24,499,000.00	17,813,754.20	(6,685,245.80)	72.71
210303	Цэвэр бохир усны зардал	24,658,800.00	25,565,176.99	906,376.99	103.68
2105	Нормативт зардал	180,623,400.00	162,525,270.00	(18,098,130.00)	89.98
210501	Эм	-	-	-	
210502	Хоол хүнс	180,623,400.00	162,525,270.00	(18,098,130.00)	89.98
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,997,600.00	(2,400.00)	99.98
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,997,600.00	(2,400.00)	99.98
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	
210702	Дотоод томилолт	-	-	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	7,045,500.00	7,041,605.00	(3,895.00)	99.94
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	7,045,500.00	7,041,605.00	(3,895.00)	99.94

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,775,300.00	44,650,633.00	(124,667.00)	99.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,758,700.00	31,635,433.00	(123,267.00)	99.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,016,600.00	13,015,200.00	(1,400.00)	99.99
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,526,107,300.00	1,283,876,398.87	(242,230,901.13)	84.13
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,449,242,700.00	1,214,353,100.00	(234,889,600.00)	83.79
131001	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,211,409,171.9	1,214,353,100.00	(234,889,600.00)	83.79
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	237,833,528.10		(237,833,528.10)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого			-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	76,864,600.00	69,523,298.87	(7,341,301.13)	90.45
132001	Орон нутгийн төсвөөс	76,864,600.00	69,523,298.87	(7,341,301.13)	90.45
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		237,833,528.10		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,762,961.04		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44.00	44.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	-	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөн аудитаар нийт 4,219.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 1,075.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,619.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 524.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн захирал О.Оюунчимэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмээдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2 дах “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Төлбөрийн акт

5.1.2 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч О.Оюунчимэгийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна олгосон байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Хичээл, практикийн зардалд лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад байхгүй материал, бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой хэрэглэгдэх, туршилт дадлагын явцад шаардагдах химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод материал, сагсан бөмбөг, хөл бөмбөг, тугалган цаас, лаа, зай, хадаас, оёдлын утас, даавуу гэх мэт хөрөнгийн бус хангамжийн материал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч О.Оюунчимэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна**", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цалин хөлс, урамшилтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.04.18-ны өдрийн Б/21 тоот тушаалаар сантехникч Д.Гантөмөрийг манаачаар хавсран ажил гүйцэтгүүлсэн байна. Хавсран гүйцэтгэсэн хугацааны цалинг тооцоолон бодоходоо МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.2-т зааснаар "түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэснийг зөрчиж үндсэн цалингаас тооцсон байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйлийн 5.1 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн тухай хууль 31 дүгээр зүйлд заасныг баримтлан, ажилчдын даатгалын төрлийг зөв бүртгэж тайлангын стандартыг мөрдөн зохион байгуулж ажиллах.

Бараа материалын данстай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт Нэг хүүхдэд хоолны зардлыг 3000 төгрөгөөс багаар 2025.4 дүгээр сард тооцож 450.0 мянган төгрөг олгосон байгаа нь МУЗГ-ын 2024 оны 237 дугаар "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйлийн 5.1 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн тухай хууль 31 дүгээр зүйлд заасныг баримтлан, МУЗГ-ын 2024 оны 237 дугаар "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах

Тайлангийн 4.4.1, 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж		
							Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн	
										-	-	-	-
Дүн										-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/											
			Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч О.Оюунчимэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс олгосон байна	1	2,619.2			1	2,619.2								
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч О.Оюунчимэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг ТҮ-7 тооцон олгоогүй байна.	1	475.2	1	475.2										

Тайлант онд тус цэцэрлэгийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч О.Оюунчимэгт олгосон байна.	1	600.0	1	600.0								
Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.04.18-ны өдрийн Б/21 тоот тушаалаар сантехникч Д.Гантөмөрийг манаачаар хавсран ажил гүйцэтгүүлсэн байна. Хавсран гүйцэтгэсэн хугацааны цалинг тооцоолон бодохдоо МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.2-т зааснаар "түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэснийг зөрчиж үндсэн цалингаас тооцсон байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар суутгаж тооцож авах	1	449.8					1	450.0				
МУЗГ-ын 2024 оны 237 дугаар "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 1-т дагуу нэг хүүхдэд хоолны зардлыг 3000 төгрөгөөс багаар 4 дүгээр сард тооцож олгосон байна.	1	74.8					1	74.8				
Дүн	5	4,219.0	2	1,075.2	1	2,619.2	2	524.8	-	-	-	-